



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/137

Улаанбаатар хот

Ёс зүйн зөвлөлийг байгуулах тухай

Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Оюуны өмчийн газрын Ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Дарга:

- Байцаагч Ч.Эрдэнэбаяр

Нарийн бичгийн дарга:

- Гадаад харилцааны мэргэжилтэн З.Гэрэлмаа

Гишүүд:

- Байцаагч Б.Цэндээхүү

- Нягтлан бодогч Э.Оюунцэцэг

- Бүтээгдэхүүний загварын шинжээч О.Оюунгэрэл

2. Зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн боловсруулж төслийг 2020 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн дотор танилцуулахыг зөвлөлийн дарга Ч.Эрдэнэбаярт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга /С.Ганзориг/-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/183 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Ц.АЗБАЯР



000815